

Монголын аман зохиол, түүхийн эх сурвалжууд дахь Абхидхармакошийн зарим ойлголтыг шинжлэх нь

С.Дэмбэрэл, докторант, ахлах багш
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: Монголд буддын шашин дэлгэрсэн тухай түүхийн эх сурвалжуудад Энэтхэгийн гүн ухаантан Васубандугийн (IV зуун) зохиосон Абхидхармакошакарикаас эшлэсэн байх нь түгээмэл байдаг. Тухайлбал “Цагаан түүх”, Сүмбэ хамба Ишбалжирын (1704-1788) зохиосон “Хутагтны орон, Их Хятад, Төвд хийгээд Монгол оронд дээдсийн ном гарсан ёс, галбарвас мод хэмээгдэх оршив”, Дармадалайн (1889) “Их Монголын оронд Дээдийн ном хэрхэн дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч, цагаан лянхуан эрхис хэмээх оршвой”, Зава Дамдины (1867-1937) “Их Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх” зэрэг түүхийн сурвалжууд болно.

Дээрх эх сурвалжуудад Абхидхармакошакарика зохиолд байдаг космологи ойлголт, тивүүдийн байрлал, зүг чиг, хэлбэр дүрс, түүнд амьдрах амьтан хийгээд төрөлхтөний өвөрмөц онцлог, бие болон насны хэмжээ, буддын шашны номлол сургаалын үзэл санаа, агуулга, Абхидхармакошакарика орчуулагдсан тухай, Монгол хаадын эрдэм чадлыг магтан “Чакраварди буюу Хүрдэн эргүүлэгч хаан” хэмээх алдар нэрийн тайлбарыг эшлэсэн байдаг.

Тус өгүүлэлд дээрх ойлголтуудыг шинжлэн, Абхидхармакошакарикийн нөлөө Монголын буддын шашны түүх бичлэгт хэрхэн нөлөөлснийг шинжлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Бурхны шашин, түүх, абхидхарма, космологи, чакраварди хаан

Монголд буддын шашин дэлгэрсэн тухай түүхийн эх сурвалжуудад Энэтхэгийн гүн ухаантан Васубандугийн (IV зуун) зохиосон Абхидхармакошаас эшлэсэн байх нь түгээмэл байдаг. Тухайлбал “Цагаан түүх”, Сүмбэ хамба Ишбалжирын (1704-1788) зохиосон “Хутагтны орон, Их Хятад, Төвд хийгээд Монгол оронд дээдсийн ном гарсан ёс, галбарвас мод хэмээгдэх оршив”, Дармадалайн (1889) “Их Монголын оронд Дээдийн ном хэрхэн дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч, цагаан лянхуан эрхис хэмээх оршвой”, Зава Дамдины (1867-1937) “Их Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх” зэрэг түүхийн сурвалжууд болно.

Дээрх эх сурвалжуудад Абхидхармакоша зохиолд байдаг космологи ойлголт, тивүүдийн байрлал, зүг чиг, хэлбэр дүрс, түүнд амьдрах амьтан хийгээд төрөлхтөний өвөрмөц онцлог, бие болон насны хэмжээ, буддын шашны номлол сургаалын үзэл санаа, агуулга, абхидхармакоша орчуулагдсан тухай, Монгол хаадын эрдэм чадлыг магтан “Чакраварди буюу Хүрдэн эргүүлэгч хаан” хэмээх алдар нэрийн тайлбарыг эшлэсэн байдаг.

Тус илтгэлд дээрх ойлголтуудыг шинжлэн, Абхидхармакошийн нөлөө Монголын буддын шашны түүх бичлэгт хэрхэн нөлөөлснийг шинжлэхийг зорилоо.

Монголчуудын ертөнцийг үзэх үзэл, сав шим ертөнцийн зүй тогтол, дөрвөн махбод, тивийн байрлал, чиглэл, цаг хугацаа, галавын тухай ойлголт, ертөнцийн өөрчлөлт хувирал, хаант төр ёс үүссэн тухай, хааны эрдэм чадал, ёс зүйн тухай мэдлэгт буддын шашин нэлээд нөлөө үзүүлсэн байдгийг Васубандхугийн Абхидхармакошакарика бүтээл, монголын түүхийн эх сурвалж, монголд буддын шашин дэлгэрсэн эх сурвалжуудаас мэдэж болно.

Монголчуудын түүх, шашин, соёл сэтгэлгээнд ихээхэн нөлөөлсөн “Абхидхармакошакарика буюу Илт номын санг шүлэглэсэн тайлбар” зохиолыг бүтээгч Васубандху (санскрит хэлээр Vasubandhu, төвөд хэлээр Егнин) нь бярманы гэр бүлд Хутагт Асангийн дүү болон М.Э-ний 4-р зууны үед Гандхарын хаант улсын Пурусаспура буюу одоогийн Пешавар хотод мэндэлжээ. Буддын судлалын эрдэмтэн Стефан Анакерын шинжлэн тогтоосноор Васубандхуг М.Э-ний 316 оны үед мэндэлсэн (Potter, 1999, p. 483) гэж үздэг. Васубандхугийн

намтарын дөрвөн хувилбарыг Парамартха (МЭ 499-569) болон Шуан-цан (МЭ 602-664) нар хятад хэлээр, Бүдон (МЭ 1290-1364), Дарнатын гэгээн (МЭ 1575-1634) нар төвөд хэлээр бичсэн байдаг.

Васубандху буддын гүн ухааны талаар 38 бүтээл (Ganden Phodrang, 2001, p. 62-67) туурвиснаас Абхидхармакошакарика (Chos mnon pa'I mdzod kyi tshig le'ur byas pa) зохиол нь ихэд алдаршжээ. Түүний Абхидхармакошакарика зохиол нь Буддагийн номлосон Абхидхармын сав аймгийн долоон эх сурвалжийг эмхэтгэн нэгдсэн, цогц, ойлгомжтой, тодорхой дэс дараалалд оруулж логик уялдаа холбоотой, нэвтэрхий толь мэт тайлбарлан бичсэн онцлогтой.

Абхидхармакошакарика зохиол дараах найман бүлэгтэй бичигджээ.

1. Язгуурыг үзүүлсэн орон
2. Эрхтнийг үзүүлсэн орон
3. Ертөнцийг үзүүлсэн орон
4. Үйлийг үзүүлсэн орон
5. Нарийн дэлгэрэнгүйг үзүүлсэн орон/сэтгэлээс гарах зэрэг ойрын нисванис, орон оронтон, буруу үзэл/
6. Мөр ба бодьгалыг үзүүлсэн орон
7. Билгүүнийг үзүүлсэн орон
8. Тэгш орохыг үзүүлсэн орон эдгээр болно.

Наймдугаар бүлгийн төгсгөлд бодьгал хэмээх ойлголт, түүнтэй хамаатай би, би-үгүй гэсэн ойлголтыг хавсралт болгон оруулсан байдаг. Абхидхармакошакарика бүтээлд бүлгийг “орон” хэмээн нэрлэсэн нь тухай бүлгийн сэдвийг тайлбарласан цогц мэдлэгийг багтаасан учраас тийнхүү нэрлэжээ.

Абхидхармын сав аймагт багтсан судруудын гол утгыг хураан товч тайлбарласан Абхидхармакошакарика бүтээлийн ертөнцийг үзүүлсэн орон хэмээх гуравдугаар бүлэгт дурдсан сүмбэр уул, галав, тив, чакравардийн⁵¹ хаан гэх ойлголтууд нь монголын үлгэр домог, ерөөл, туульсад түгээмэл дурдсан байдгаас гадна бөөгийн дуудлага, монголын түүхийн эх сурвалж бичгүүдэд түгээмэл байдгийг энэхүү өгүүлэлдээ тодруулахыг зорив.

Монгол аман зохиолд ертөнцийн үүсэл, сүмбэр уулыг дурдах болсон тухай

Монгол ардын аман зохиол “Бэр галд мөргөхөд ерөөх ерөөл”, “Түүний сүүний цацлын судар”, “Галын тахилга”, “Гал тахих ёсон”, “Шувууны даллага”, “Ангийн сан” бүтээлүүдэд Сүмбэр уул, Анабад далай, ганга мөрөн, замбуутив, галав, загарварди гэх абхидхармакошагийн сав шим ертөнцийн зүй тогтолтой холбоотой нэршлүүд байна. Абхидхармакошад дурдсан ертөнцийн төв болсон сүмбэр уулыг монголчууд аман зохиолдоо “Сүмбэр уулыг довон бүхүйгээс” (Дамдинсүрэн, 2017, хууд. 146) хэмээн ертөнцийн үүсэл, балар эрт цагийг үлгэрлэн үзүүдэг бол “Сүмбэр уул мэт цог жавхлан нэмтүгэй” (Дамдинсүрэн, 2017, хууд. 124), “Чин сүмбэр уул мэт цогтой болоод” (Дамдинсүрэн, 2017, хууд. 145) гэж сүр жавхлан, цог хийморийн бэлгэдэл болгохоос гадна бат бөхийг илэрхийлж “Сүмбэр уул мэт эвдэршгүй” (Дамдинсүрэн, 2017, хууд. 151), буян хишиг хуран цуглах, тогтохыг “Сүмбэр уул мэт цогцолтугай” (Дамдинсүрэн, 2017, хууд. 153) гэж ерөөн “Сүмбэр уулнаа дүүрэн ес цацнам” (Дамдинсүрэн, 2017, хууд. 127) хэмээн цагаан идээний дээжээ өргөж ерөөдөг байна. Үүнээс үзвэл дээр дурдсан Монголын ардын аман зохиолд Сүмбэр уулыг өндөр, сүр жавхлантай, бат бөх, эвдэршгүйн бэлгэдэл болгон дүрсэлж байна. Харин сав ертөнц бүрэлдэн тогтоход Сүмбэр уул хэрхэн үүссэн, түүний бүтэц, өндөр, эргэн тойрон хүрээлэн буй уулсын мөн чанар, хэлбэр дүрс, нуур далай,

⁵¹ Хуучны аман ярианд “загарварди” гэж дууддагийг өгүүлэлдээ “чакраварди” хэмээн бичив

тивийн зүг чиг, хэмжээ, хэлбэр дүрс, онцлог байдлыг XVII зуунаас эхлэн бичигдэж эхэлсэн монголын түүхийн эх сурвалжууд шиг тодорхой дурдаагүй байдал ажиглагдана.

Абхидхармакошад дурдсан буддын космологи тайлбарт орчлон ертөнц хязгааргүй бөгөөд байгалийн хуульд захирагдан үргэлж өөрчлөгдөн хувирч, галав галаваар үүсч, оршин тогтнож, эвдэрч, дахин үүсэх зэргээр цагийн эргэлтээр хувирч өөрчлөгдөн байдаг гэж үзнэ. Энэхүү орчлон ертөнцийн оршин тогтнох галавын тухай үзэл санаа ч эртний монгол домогт нөлөөлсөн байдгийг С.Дулам монголчуудын ертөнцийн үүслийн тухай “Галбын”⁵² үлгэр” (Дулам, 2009, хууд. 188) хэмээх домог туулийн судалгаандаа дурджээ. Тэрээр галав хэмээх ойлголтыг тайлбарлахдаа абхидхармакошад байдаг галавын төрөл зүйл, онцлог, галавыг эзэгнэгч бурхад, сүмбэр уул үүссэн тухай тайлбарласан байна.

Буддын космологи үзлээр дүрс үгүй ертөнц, дүрст ертөнц, хүслийн ертөнцөд хамаарах гучин нэгэн орон оршдог байна. Ертөнцийн төвд Сүмбэр уул орших бөгөөд түүнийг тойрон алт, мөнгө, зэс, төмөр уулс оршин тэдгээр уулсаас гол горхи урсан, гадаад их далайд цутгана, тэрхүү гадаад их далайд дөрвөн их тив, найман завсарын тив оршино хэмээн абхидхармакошад дурдсан буй.

Монголд буддын шашин анх дэлгэрсэн үеэс МЭӨ III зуунаас эхлэн бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзэл, мөргөл залбирал, дуудлагад буддын шашны нэр томъёо, ойлголтууд аажмаар хэрэглэгдэх болжээ.

Эртний бөө мөргөлд тэнгэр газар хоёр нэгэн үед нэгдмэл цул эд байгаад газраас тэнгэр салах үед гал үүссэний дээр тэнгэр нь амь оруулж, эр үүтгэл, газар нь хэлбэр дүрс өгсөн учир эм үүтгэл болсоноор монголчууд эцэг тэнгэр, эх газар дэлхий (Банзаров, 2007, хууд. 20) хэмээн нэрлэдэг болсон тухай Дорж Банзаровын (1891) бүтээлд дурдсан байна. Монголчуудын байгаль шүтлэг, нутаг орны шүтээн уулын гол овоог тойруулан 12 овоо босгох ёс нь абхидхармын космологи дүрслэл нөлөөлсний илрэл бөгөөд гол овоо нь Сүмбэр уулыг төлөөлж, түүнийг тойрсон 12 овоо нь дэлхийн хэсэг ба тивийг (Банзаров, 1891, с. 20) илэрхийлэх болсон байдаг. Ийнхүү Монголчуудын шүтдэг арван гурван овоо нь Абхидхармакоша дахь дэлхий ертөнцийг төлөөлсөн дүрслэлийг илэрхийлэх болжээ.

Буддын шашны гурав дахь дэлгэрэлт ба абхидхармын зохиолууд монголд дэлгэрсэн тухай

Буддын шашин монголчуудын дунд хүчтэй дэлгэрсэн XVI зуунаас эхлэн “Монголчуудын хуучны түүхийн сэтгэлгээ нь Энэтхэг, Хятад, Түвэдийн түүхийн ухааны хүчтэй нөлөөн дор хөгжсөн байна” (Бира, 2001, хууд. 16) гэж судлаачид үздэг. Энэ үеийн монголын түүхчдийн дунд түүх бичлэгийн тогтсон дэг ёс буй болж Абхидхармакошад дурдсан сав шим ертөнцийн үүсэл ба тивүүдийн тогтоц, байгуулалт, түүн дээр орших хүний амьдралын хугацаа, галав, хаант төр анх үүссэн ёс болон хааны эрдэм чадал, эрхэм чанар, ёс суртахууны тухай өгүүлэх болжээ. Мөн Ш.Бира Монголчууд дундад зууны түүх бичлэгт “өөрийн орны түүхийг бичихийн өмнө Энэтхэг, Хятад ялангуяа Түвэдийн түүхийг ямар нэгэн хэмжээгээр өгүүлэх ёстой гэж үзэн эдгээр улсын түүхийн баялаг хэрэглэгдэхүүнийг уг эхээр нь чадварлаг ашиглаж чаддаг байсан” (Бира, 2001, хууд. 16) гэжээ. Тэгвэл Монголын түүхчид түүхийн эх сурвалжаас гадна буддын гүн ухааны өндөр мэдлэгтэй байсан нь абхидхармакошад байдаг ертөнцийн үүсэл, цаг хугацаа, хаант төрийн үүслийн тухай ойлголтууд тэдний түүхийн бүтээлүүдэд тодорхой дурдагдаж буйгаар илэрнэ.

Абхидхармын аймгийн гол эх сурвалжууд, гол өгүүлэгдэхүүн, бүтэц, агуулга, үзэл санаа, нэр томъёо, ойлголт, ангилалыг Монголчууд буддын шашны шастирын цоморлиг “Данжуур”-ыг орчуулахдаа Жанжаа хутагт Ролбийдоржоор удирдуулсан олон орчуулагчид “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” (1740-1742) бүтээлдээ тайлбарласан байдаг.

⁵² Хуучны эх сурвалжид голдуу “галба” гэснийг өгүүлэлдээ “галав” гэж бичив.

Тус бүтээлийн дараа Монголчууд Данжуурт орсон Абхидхармын 10 гаруй бүтээлүүдийг орчуулан таван мэдрэхүй, таван цогц, арван хоёр төрөн түгэхүй, арван найман язгуур, хорин хоёр эрхтэн, сав шим ертөнцийн ёс, галав, цаг хугацаа, үйлийн үр, сэтгэлийн хэв шинжүүд, ёс суртахуун, гэгээрлийн зам мөр, бэлгэ билгүүн, бясалгал, сэтгэл төвлөрлийн тухай мэдлэгийг доорх шастируудаас судалж иржээ. Үүнд:

1. “Ил номын сангийн үгсийг бүлэглэсэн”, Абхидхармакошакарика (Chos mnon pa’I mdzod kyi tshig le’ur byas pa), Монгол данжуурын гарчиг: 151-р боть, 3487, зохиогч Васубандху, орчуулагч Jinamitra, Dpal brtsegs, IX зуун
2. “Ил номын санг номлогч”, Абхидхармакоша бхашъяа (Chos mnon pa’I mdzod kyi shad pa), Монгол данжуурын гарчиг: 151-р боть, 3488, зохиогч Васубандху, орчуулагч Jinamitra, Dpal brtsegs, IX зуун
3. “Абхидхармакошийн шастирын бүлэглэсэн тийн номлол”, Абхидхармакоша шастра карика бхашъяа сутранурапа нама (Chos mnon pa’I mdzod kyi btsan bcos kyi tshig le’ur byas pa’I nam par bsad pa mdo dan mthun pa zes bya pa), Монгол данжуурын гарчиг: 152-р боть, дугаар 3488, зохиогч Vinatabhadra, Sanghabhadra, орчуулагч нь тодорхойгүй, IX-XI зуун
4. “Абхидхармын сангийн тайлбар”, Абхидхармакоша вьяакъяа спутартха нама (Chos mnon pa’I mdzod kyi ‘grel shad don gsal ba zes by aba), Монгол данжуурын гарчиг: 153, 154-р боть, 3490, зохиогч Rajaputra Yasomitra, орчуулагч Visuddhasinha, Dpal brtsegs, IX зуун
5. “Абхидхарма сангийн тайлан номлосон бэлгийн чанарын хойноос дагагч”, Абхидхармакоша тика лакшананусарини нама (Chos mnon pa’I mdzod kyi ‘grel shad mtshan nid kyi rjes su ‘bran ba zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 155,156-р боть, 3491, зохиогч Purnavardhana, орчуулагч Kanakavarman, Pa tshab ni ma grags, XII зуун
6. “Ном ил сангийн тайлбар номлол чухал хэрэглэгч хэмээх”, Абхидхармакоша тика упайека нама (Chos mnon pa’I mdzod kyi ‘grel shad ne bar mkho ba zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 157, 158-р боть, 3492, зохиогч Samathadeva, орчуулагч Jayasri, Ses rab ‘od zer, XIV зуун
7. “Абхидхармын тайлбар оньсоны зул хэмээх”, Абхидхармакоша вритти мармапрадипа нама (Chos mnon pa’I mdzod kyi ‘grel pa gnad kyi sgron ma zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 158-р боть, 3493, зохиогч Dignaga, орчуулагч Rnal ‘byor zla ba, ‘ Jam dpal gzon nu, XIII зуун
8. “Абхидхармын гуу сангийн тайлбарыг номлосон бэлгэ чанарыг дагагч нэрт”, Абхидхармакоша тика лакшананусарини нама (Chos mnon pa’I mdzod kyi ‘grel shad mtshan nid kyi rjes su ‘bran ba zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 158-р боть, 3494, зохиогч Purnavardhana, орчуулагч Kanakavarman, Pa tshab ni ma grags
9. “Абхидхарма дор орох ахуй их тайлбар хамаг зүрхнээс төгсгөсөн хэмээх”, Абхидхармаватара тика сарасамуччаяа нама (Chos mnon pa la ‘jug pa rgya cher ‘grel pa snin po kun las btub pa zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 158-р боть, 3495, зохиогч тодорхойгүй, орчуулагч Jinamitra, Danasila, Ye ses sde, XIV зуун
10. “Сайтар үйлдэгч абхидхарма дор орохуй хэмээх”, Абхидхармаватара пракарана (Ra tu byed pa chos mnon pa la ‘jug pa zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 158-р боть, 3496, зохиогч Skandhila, орчуулагч тодорхой бус, V зуун
11. “Абхидхармын сангийн утгыг тэр ямагт чанарыг номлохын агуу их тайлбар хэмээх”, Абхидхармакоша бхашъяа тика таттвартха нама (Chos mnon pa’I mdzod kyi shad pa’I rgya cher ‘grel pa don gyi de kho nan id zes bya ba), Монгол данжуурын гарчиг: 217,218-р боть, 3772, зохиогч Sthiramati, орчуулагч Dharmapalabhadra, бичээч Sans rgyas ‘ phel, XV зуун, зэрэг зохиолууд орно. Эдгээр Монгол данжуурын Абхидхармын тайлбар зохиолуудыг Монгол буддын гүн ухааны дацан сургуульд үзэж судалсан монгол лам нар Абхидхармын тухай дараах тайлбар бүтээлүүдийг туурвисан байдаг. Үүнд:

Торгуудын хошууны Лувсанжамба лам (XVIII зуун) билиг барамид, абхидхармын сэдвээр нэг боть бүтээл бичсэн байна.

Гавж Агваанбалдан, “Илт номын сангийн шинжилгээ багачуудын оюуны цэнгэл” хэмээх тайлбар зохиолыг бичжээ.

Цахар гэвш Лувсанчүлтэм “Махбодь хийгээд махбодиос болсон”,

Оргиочийн лам гавж Лувсанбалдан “Таван цогцын тайлбар”,

Их хүрээний хамба номун хан Агваанхайдав “Сэтгэлээр бусдын хэрэг ямагтыг ямар мэт үйлдэхийн намтар өлөг, мэдэл, төгс бус хуран үйлдэгчийн яриа”,

Бари лам Дамцагдорж “Сав шим ертөнцийн байдал, шашины гарсан ёсыг өгүүлсэн эрдэнийн зул”,

Гавж Лувсанцэрэн “Илт номын сангийн найман орны тайлбар” зэрэг бүтээлүүдийг туурвиж, монголын уламжлалт гүн ухааны өвөрмөц бичлэг, мэтгэлцээний арга хэлбэрээр тайлбарлан хойч үедээ үлдээсэн байна.

Баруун хүрээний цорж Гончогжалцан (XX зууны эхэн үе) абхидхарма, винайн тайлбар бичиж нэг боть бичмэл зохиолдоо багтаажээ. Их хүрээний гавж Жамц (XX зуун) абхидхарма, винай буюу ёс зүйн сэдвээр бүтээл туурвиж байв. Сайн ноён хан аймгийн Түшээт вангийн хошууны цорж Лувсанчимиддорж (XX зуун) хоёр боть зохиолдоо абхидхармын тайлбар бичиж оруулжээ. Эдгээр Абхидхармакошийн тайлбар зохиолуудад буддын шашны гол ойлголтуудаас гадна ертөнцийн үүсэл, бүтэц, зүй тогтол, түүнд орших шим ертөнцийн төрөл зүйл, амьдралын онцлогийг тайлбарласан байдаг.

Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Абхидхармакоша шастир дахь ертөнцийн үүсэл, зүйл тогтлыг дурдах болсон тухай

Абхидхармакоша зохиол дахь ертөнцийн зүй тогтолын тухай ойлголтыг дараах байдлаар дүрсэлсэн байдаг.

समन्ततस्तु त्रिगुणं तत्र मेरुर्गन्धरः।

ईशाधारः खदिरकः सुदर्शनगिरिस्तथा॥४८॥

ཁོར་ལུག་ཏུ་ནི་སྒྲ་འབྱུར་རོ། །དེ་ལ་རྩུ་ན་པོ་གཞུང་ཤིང་འཛིན། །

གཤོལ་མདའ་འཛིན་དང་ཁོང་ལྔ་ཅན། །དེ་བཞིན་བཞུ་ན་སྒྲ་ལི་དང་། །

Орчин тойрон нь гурван хувь болмой.

Түүн дор Сүмэр уул, Буулга модот,

Анжсан сумт, хэтэрт⁵³,

түүнчлэн үзэсгэлэнт уул ба,

अश्वकर्णो विनितको निमिन्धरगिरिः ततः।

द्वीपाः बहिश्चक्रवाडः सप्त हैमाः स आयसः॥४९॥

རྩ་ན་དང་ནི་ན་མ་འདུད་དང་། །སྒྲ་ལྱད་འཛིན་ལོ་ལོ་དེ་ན་ལ་ནི། །

ཤིང་རྩམས་ཡིན་ནོ་དེ་དག་གི། །

བྱ་ལོ་ན་ནི་ཁོར་ལུག་སྒྲེ། །བདུན་ནི་གཞུང་ཡིན་དེ་རྩམས་སོ། །

Морин чихт хийгээд маш эхүүсэн⁵⁴ ба,

Мөхөрийг⁵⁵ баригч уул болой.

Тэндээс нь тив нүгүүд мөн болой.

⁵³ Хэтэрт (Санскрит нэршил нь khadirakah, шинжлэх ухааны нэршил нь Acacia catechu) хэмээх ой модоор хүрээлэгдсэн оргилтой уулыг ийнхүү нэрийджээ. Мэргэд гарахын оронд “хадирт” хэмээсэн байна.

⁵⁴ Бөхийсөн бөгтөр оргилтой уул. Мэргэд гарахын орон даягт “маш сөгдсөн” хэмээжээ.

⁵⁵ Хүрээ, тойрог, цагираг баригч уулыг ийнхүү нэрлэжээ. Мэргэд гарахын оронд “Мөөрийг баригч уул” хэмээжээ.

Тэдгээрийн гадаад дор нь орчин тойрог бөгөөд,

Долоон нь алтан бөгөөд төмөр болой. (Ариунаа, 2015, хууд. 16)

Дээрх Абхидхармакошийн шүлэгт сав ертөнцийн үүслийг хий, усны хот мандлын харилцан үйлчлэл, амьтны үйлийн үрээр тогтсон бөгөөд хийн язгуурын хуйларсан их хүч усны хот мандалыг эргүүлж, алтан газар дэлхийн хот мандлыг тулгуурлан найман их уул сүндэрлэсэн хэмээн тайлбарлаж байна. Эдгээр найман уулсын төвд нь сүмбэр уул оршин бусад буулга модот, анжсан сумт, хэтэрт, үзэсгэлэнт уул, морин чихт, маш сөгдсөн, мөөрийг баригч гэсэн харагдах хэлбэр дүрс, онцлог шинж нь харилцан адилгүй долоон уулс нь түүнийг тойрон байдаг. Сүмбэр уулын өндрийг уснаас дээш найман түмэн бээр дээш гарсан, уснаас доош мөн найман түмэн бээр далд оршино (Slo dpon dbyig gnyin, 1998, хууд. 247) гэсэн байдаг бол түүнийг тойрох уулс нь дөрвөн түмэн бээрийн хэмжээтэй намхан хэмээжээ. Сүмбэр уул зүүн тал нь мөнгө, урд тал нь биндэрьяа, баруун тал нь бадмаараг, хойд тал нь алт эрдэнээр бүтсэн (Rgyal ba dge 'adun 'agrub, 2000, р. 221) бол харин Сүмбэр уулыг хүрээлсэн уулс нь алтны мөн чанартай гэнэ. Сүмбэр уул тэргүүтнийг гадуур нь тойрон хүрээлэх уулс нь төмрийн мөн чанартай ажээ. Тэдгээрийг тойрсон далайд үлэмж биет тив, замбуутив, үхэр эдлэгч тив, муу дуут дөрвөн тив оршдог тухай өгүүлжээ. Эдгээр дөрвөн тивийн огторгуйд Сүмбэр уулыг бүтээдэг эрдэнэсийн өнгө тусаж өвөрмөц туяатай болгодог байна. Тухайлбал Сүмбэр уулын урд орших замбуутивын огторгуй нь биндэрьяа адил хөх өнгөөр туяардаг гэжээ.

Эдгээр Абхидхармакошийн эшлэл нь ертөнцийн төв Сүмбэр уул, түүнийг тойрсон долоон уул ба далай, түүний чинадад дөрвөн тив, найман дагуул жижиг тивийн тухай ертөнцийн бүтэц, тогтоц, дүрс хэлбэр, шинж чанар, өндөрийн хэмжээ, мөн чанарыг дүрслэдэг. Тэрхүү ертөнцийн зүй тогтол нь Монголын түүхийн дараах эх сурвалжуудад дурдагдсан байна. Үүнд:

- Саган Сэцэний (1662) “Эрдэнийн товч” (МУИС, Монгол судлалын төв, 2006)
- Шамбадар Цогт ахай (XVII зуун) “Эртний Монгол хаадын үндэсний их шар тууж оршив” (МУИС, Монгол судлалын төв, 2006)
- Гүүш Лувсанданзаны (XVII зуун) “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч” (МУИС, Монгол судлалын төв, 2006)
- Мэргэн гэгээн Лувсамдамбийжалцаны (XVIII зуун) “Алтан товч” (МУИС, Монгол судлалын төв, 2006)
- Галдан туслагч (1841) “Эрдэнийн эрх хэмээх түүх болой” (МУИС, Монгол судлалын төв, 2006)
- Сүмбэ хамба Ишбалжир, (1748) “Галбарвас мод хэмээх шашны түүх” (Сүмбэ хамба Ишбалжир, 2017)
- Дармадалагийн (1889) “Монгол орноо бурханы шашин дэлгэрсэн түүх” (Дармадала, 2016)
- Зава Дамдин гавжийн (1931) “Алтан дэвтэр” (Зава Дамдин, 2018)

Саган Сэцэн Эрдэнийн товч (1662) зохиолдоо ертөнцийн зүй тогтлын тухай: Их эрхэт Алтан дэлхий нэрт шороон мандал, дунд нь уулсын хаан жавхлант Сүмбэр таг, долоон алтан уулс, долоон Анабадын нуур⁵⁶, дөрвөн их тив, найман өчүүхэн тив лүгээ арван хоёр тивүүд нэгэн цагт тогтвой (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 19) хэмээн орчлонгийн үүсэл, бүтэц, зохион байгуулалтыг дүрсэлжээ.

Шамбадар Цогт ахай “Эртний Монгол хаадын үндэсний их шар тууж оршив” (XVII зуун) зохиолд “Тэр далай хийеэ бүлэгдэж хийгээр бүлүүлж хөр. Тоосон гарсан нь Сүмэр⁵⁷ уул, долоон алтан уул, дөрвөн тив бүтвэй. Сүмэр уулын талс нь зүүн мөнгөн, өмнө байдурьяа, баруун бадмаараг, хойд тал алтаар бүтсэн буюу. Сүмэр уулын найман түмэн бээр нь далай дотор, найман

⁵⁶ Санскрит хэлээр “anavatapta”, төвөдөөр “mtso ma dros pa”, замбуутивийн бүх гол мөрний эх болсон “эс бүлээцсэн далай” гэдэг

⁵⁷ Хуучны аман зохиолд Сүмбэр уулыг Сүмэр гэж бичих тохиолдлууд байна

түмэн бээр нь усны дээр буюу. Тивүүд шороогоор бүтсэн буй. Дөрвөн тивийн гадуур төмөр хүрээ буюу. Сүмэр уулын өмнө энэ замбутив тэргэний арлын дүрт, замбутивийн дунд нь Магада нэрт буюу” (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 33) хэмээжээ.

Гүүш Лувсанданзаны “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч” (XVII зуун)

Энэхүү түүхийн эх сурвалжид ертөнцийн зүй тогтлын талаар дэлгэрэнгүй дурдсан зүйлгүй боловч “Эрт цагт замбутивийн хүн нь хувилж төрьюу” (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 27) хэмээн замбуутивд хүний амьдрал үүсч, тэднийг үнэн, худал хоёрыг ялгаж зааглан удирдагч Маха Самади буюу Олноо өргөгдсөн хаан засаглах болсон тухай дурджээ.

Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны “Алтан товч” (XVIII зуун) дахь ертөнцийн зүй тогтлын талаар Сүмбэр уулын гадуур давхар хүрээлэн, дотроос зэргээр Буулга баригч, Дөрвөлж баригч, Гадараа модот, үзвээс гоо, морин чихт, маш бөгтөр, маш баригч хэмээн долоон давхар хүрээлэх уул цөм алтаар бүтэв. Тэдгээрийн хувь нь усаар дүүрээд тунаж цэнгэлдэхүй долоон нуур болон тэр нуур доторт алтан хойг аж, жаргалангийн орд хэмээн бүтэв ... Элдэв язгуурын эрдэнийг хураагаад дөрвөн тив хэмээн нэгэн их тивд нь хоёр хоёр бага тивийг багцаалаад Сүмбэр уулын дөрвөн зүгт арван хоёр тив аж (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 21) хэмээн дээрх эх сурвалжуудтай адил бичсэн байна.

Галдан туслагч “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” (1841)

Тус түүхийн эх сурвалжид сав ертөнцийн бүтцийг хий, ус, шороон мандлаас тогтож, түүний “Дундад нь уулсын хаан жавхлант Сүмбэр таг долоон алтан уулс, долоон Анурад нуур⁵⁸, дөрвөн их тив, найман өчүүхэн тив лүгээ арван хоёр тивүүд нэгэн цагт тогтов (МУИС, Монгол судлалын төв, МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим, 2006, хууд. 29) хэмээн дүрсэлсэн байна.

Сүмбэ хамба Ишбалжир “Галбарвас мод хэмээх шашны түүх” (1748)-д: Галав тогтсон ёс: “Анхдугаар нь үйлээс элдэв ертөнц төрмүй” хэмээн номлосон мэт ертөнцийн орон алинд төрөх болохын нийт амьтны үйл хурааснаас эзлэх үр, сав шим ертөнц тэнд гарах бөгөөд (Сүмбэ хамба Ишбалжир, 2017, хууд. 3)... Ерд галавт эвдрэх, хоосон, тогтох, орших дөрөв буй бөгөөд эвдрэхэд хий, гал, ус гурав бөгөөд” гэж ертөнцийн үүсэл, орших галав, эвдрэх шалтгааныг дурдсан байна. Сүмбэр уул тогтсоны дорно мөнгө, өмнө биндэрья, өрнө улаан болор буюу бадмаараг, умар алтнаас бүрдсэн эрдэнийн мөн чанарт бөгөөд дөрвөн зүгийн чимэг огторгуй хийгээд далайн өнгийг ч тэр дөрвөн эрдэнэ тус тусын өнгөнд номлосон бөгөөд түүний гадуур Буулга баригч, Анжисны сум баригч, Хадирт, Үзвээс гоо, Морин чихт, Тийн эхийсэн, Мөөр баригч уул бөгөөд долоон алтан уулаар дөрвөлжлөн хүрээлсэн болой. Замбутив, үлэмж биет, үхэр эдлэгч, муу дуут тив (МУИС, Монгол судлалын төв, МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим, 2006, хууд. 4) хэмээн огторгуй, далай, уулс, тивийн мөн чанарыг дурджээ.

Дармадалайн “Монгол орноо бурханы шашин дэлгэрсэн түүх” (1889) зохиолд:

Зохиогч бээр “Энэхүү ертөнцийн доорд газар ба далай нь гурван муу заяаны орон мөн хийгээд Сүмбэр уулын усны дээд захаас доошхи хөндий тэргүүтэн нь Асурын орон мөн бөгөөд долоон алтан уулаас Сүмбэр уулын оргил хүртэл хийгээд түүнээс дээшхи орон нь тэнгэрийн орон мөн ба, дундах арван хоёр тив нь хүний орон мөн бөгөөд, тэдгээрээс өмнийн гурван тивийн дундах нь тивийн дээд болсон Замбутив энэ мөн бүлгээ” (Дармадала, 2016, хууд. 38) гэж Сүмбэр уулаар баримжаа авч дээд тэнгэрийн орон, дунд хүний орныг тодорхойлжээ.

Дармадалай Энэтхэг, Хятад, Төвөд оронд бурханы шашин дэлгэрсэн үед ертөнцийн зүй тогтол, Сүмбэр уул, түүний эргэн тойрны долоон уулс, дөрвөн тивийг дүрслэн үзүүлээгүй атал зөвхөн Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн ёсыг өгүүлэхдээ гурван сайн төрөл болох

⁵⁸ Санскрит хэлээр “anavatapta”, төвөдөөр “mtso ma dros pa”, замбуутивийн бүх гол мөрний эх болсон “эс бүлээцсэн далай” гэдэг

Абхидхармакошад дээрх үндсэн шүлгийг тайлбарлахдаа сайн цагийн галавт мянган бурхан залрахаас гадна хүрдэн⁵⁹ орчуулагч⁶⁰ хаан залардаг хэмээжээ. Хүрдэн орчуулагч хаан нь хүний нас хэмжээлшгүйгээс наян мянга наслах хүртэл ертөнцөд төрөх бөгөөд өөрийн сүр хүч, чадал, зэр зэвсэг, хүрдээр төрийг засах болно. Хүрдэн эргүүлэгч хааныг эрдэм чадал, сүр хүчээр нь эрхэм дээд буюу алтан хүрдэт хаан, дээд буюу мөнгөн хүрдэт хаан, дунд хүчит буюу зэс хүрдэт хаан, бага хүчит буюу төмөр хүрдэт хаан гэж ангилдаг байна.

Эрхэм дээд хаан дөрвөн тивийг эрхшээдэг бол, дээд хаан гурван тив, дунд хүчит хаан хоёр тив, бага хүчит хаан ганц тивийг эрхшээнэ (Slo dpon dbyig gnyin, 1998, хууд. 292-293) гэж дурджээ.

Хүрдэн эргүүлэгч хаан нь нэг цаг үед, замбуутивд бурхан мэт ганц л төрдөг, бусад хаантай ханьцашгүй их сүр жавхлан, хүч чадлыг эрхшээдэг байна. Бурхан ганцаар номын хүчээр хамаг амьтныг номхотгохтой адил хүрдэн эргүүлэгч хаан ганцаар төрийг засах чадалтай хэмээнэ.

Алтан хүрдэн эргүүлэгч хааны сүр хүчээр эргэн тойрны улсын хаад төдийгүй сөргөлдөгч хаад ч өөрсдөө аяндаа түүнийг даган ордог байна. Мөнгөн хүрдэн эргүүлэгч хаан мордох төдийгөөр цаад тэмцэгч талыг эрхэндээ хураадаг. Зэс хүрдэн эргүүлэгч хаан дайнд бэлдэх төдийгөөр бусдыг эрхшээдэг бол төмөр хүрдэт хаан нь зэр зэвсэг агсах төдий амьтанд хорлолгүйгээр дайснаа буулган авдаг (Mi pham gnam rgyal rgya mtsho, 1998, p. 174) хэмээжээ. Үүнээс үзвэл “хүрдэн эргүүлэгч хаан”-ыг улс орноо номын ёсоор зөв шударга удирдах ухаан, орчлонд эзлэх байр суурь, сүр хүч нөлөө, эд баялаг, зэр зэвсэг, үнэнч шударга сайд түшмэл, эрүүл бие, төгс дүр төрх, урт удаан нас, нэр алдар, өглөг буянд шамдсан, ёс суртахуунтай, өөрийгөө улс, ард түмнийхээ төлөө зориулдаг, үнэнч, энэрэн нийгүүлэх сэтгэлтэй, тэвчээртэй, эв нэгдлийг эрхэмлэдэг, өөрийгөө хянадаг, тайван амгалан, хүчирхийлэлээс зайлсхийх бодлого баримталдаг байдлаар нь эрдэнэсээр тодотгон эрэмбэлдэг ажээ.

Хүрдэн эргүүлэгч хаан нь номын ёсыг сахиулахдаа хүрд, заан, ажнай хүлэг, чандмань эрдэнэ, хатан эрдэнэ, цэргийн жанжин, түшмэл гэсэн хаан төрийн долоон эрдэнийг эрхэндээ хураасан, эд эдлэл төгс нэгэн байх ёстой гэнэ. Мөн тэр их хаан нь ойрын долоон эрдэнэ болох илд, хонины арьс, сэнтий, ор, олбог, сүйх тэрэг, гутал зэрэг зэр зэвсэг, эд баялагийг хураан эзэмшиж, олноо суу алдар нь түгэн дэлгэрдэг ажээ.

Абхидхармакоша шастирт дурдсан “хүрдэн эргүүлэгч хаан буюу чакраварди хаан” гэдэг үгийн үүсэл гарал, судар шастирт анх хэзээ хэрэглэгдэх болсныг судлаач Сунайт Чутинтаранонд (1988) судлан хиндү шашны “Самвидана Брахмана”, “Майтри Упанишадад” дурдагдсан байна (Sunait Chutintaranond, 1988) гэж үзжээ. Мөн судлаач Кюун Жоон Пак (2002) “Чакраварди” гэх үгийн гарал үүсэл, хэрэглээг Буддагаас өмнө, эсвэл Маурын эзэнт гүрний Ашока хааны дараа үүссэн эсэхийг нягтлан шинжилж, Буддагийн үед энэ үгийн утга агуулга илүү тодорхой болж хэрэглэгдэн хожим Ашока хааны засаглалын дараа илүү боловсронгуй болж дэлгэрсэн (Kyoung-joon Park, 2002) гэж тодруулжээ.

Тэгвэл Бурхан багшийн намтарыг өгүүлсэн “Агуу их цэнгэсэн судар”-ын Бурхан багш эхийн хэвлийд оршсон зургаадугаар бүлэгт “чакраварти буюу хүрдэн орчуулагч хаан” гэх нэр, ойлголтыг анх дурдсан байдаг. Тус бүлэгт Махамаяа хатан хөл хүнд болж нэгэн шөнө тэнгэрт их гэрэл гарч ер бусын үзэсгэлэнт нэгэн заан түүн рүү чиглэн ирж шингэж буй зүүд зүүдлээд Сайн идээт хаанд хэлэхэд зүүдийг тайлдаг мэргэн бярман нарыг дуудан ирүүлж зүүдний учрыг асуухад тэд дараах байдлаар тайлбарлажээ.

⁵⁹ Хиндү шашны Вишнү тэнгэр орчлонг хамгаалахдаа “Чакра” буюу “Хүрд”-ээр зэвсэглэсэн байдаг. Тиймээс энэтхэг уламжлалаар орчлонг хамгаалах үүрэгтэй хаан энэ зэвсгийг эзэмшсэн байх ёстой гэж үздэг.

⁶⁰ “Хүрдэн орчуулагч” гэдэг нь мөн “Хүрдэн эргүүлэгч” гэсэн утгатай.

वचनमिमु श्रुणित्वा ब्राह्मणा एवमाहुः

प्रीति विपुल चिन्त्या नास्ति पापं कुलस्य।

पुत्र तव जनेसी लक्षणेभूषिताङ्गं

राजकुलकुलीनं चक्रवर्ति महात्मं॥११॥

དེ་སྐད་ཚིག་ཐོས་ནས་ནི་བཅ་ཟེ་རྒྱལ་གྱིས་འདྲི་སྐད་སྒྲིག་།

རིགས་ལ་དངོ་བ་མ་མཆིས་དགེས་བ་རྒྱ་ཆེན་བརྟེན་བར་ལྷུང་།

ཁྱེད་ལ་སྐས་མངའ་མཆོན་གྱིས་ཡན་ལག་བརྒྱན་བ་སྐྱེ་བར་འཁྱུར་།

རྒྱལ་པོ་དེ་རིགས་སུ་རིགས་ལྡན་འཁོར་ལོས་བརྒྱར་བ་ཆེ་བ་ནིང་།

“Тийн сонсоод бярманууд бээр ийн өгүүлвэй

Та санаа зовох зүйлгүй, их баярт үйл тохиох нь

Танд сайн бэлгэ чанар гишүүн төгөлдөр ханхүү төрөх нь

Хаан болвол ухаан төгөлдөр хүрдэн эргүүлэгч хаан болно” хэмээн бурхан багшийг хэрэв хаан болвоос дэлхийг эзэлсэн “чакраварди буюу хүрдэн эргүүлэгч хаан” болохыг зөгнөжээ. Үүнээс үзвэл Бурхан багшийг мэндлэхээс өмнө энэтхэгийн нийгэм, улс төрийн сэтгэлгээнд нөлөө бүхий хааныг “чакраварди буюу хүрдэн эргүүлэгч” хэмээн нэрлэдэг байсан нь тодорхой байна.

Тэрхүү нэршлийг хожим буддын сэтгэгчид авч хэрэглэснээр буддын түүхийн эх сурвалжуудад дурдах болжээ. Эртний Энэтхэгийн Маурын эзэнт гүрний хаан Ашока хааныг (НТӨ 268-232) буддын шашныг сахин хамгаалагч номын хаан, “чакраварди” хаан хэмээн алдаршуулах болжээ. Түүнээс гадна буддын шашин дэлгэрсэн Бирм, Тайланд улсууд өөрсдийн хүчирхэг хаадыг ч мөн “чакраварди” хаан хэмээн өргөмжилдөг тохиолдлууд байна. Тухайлбал Бирмийн хаан Кянситта (1084-1111), Сиамын хаан Трилок (1448-1488) нар “чакраварди” хэмээх алдар цолтой байжээ.

Монголд буддын шашин гурав дахь удаагаа дэлгэрсэн Түмэдийн Алтан ханы (1507-1582) үеэс Монголын буддын шашны түүх бичлэгт зарим монгол хаадыг “хүрдэн эргүүлэгч хаан” хэмээн өргөмжлөн бичих болжээ.

Тэгвэл “хүрдэн эргүүлэгч хааны” эрдэм чадал, эрх мэдэл Монгол хаадад хэрхэн бүрдсэнийг дараах түүхэн эх сурвалжуудад хэрхэн дүрслэсэн буйг шинжилвээс:

“Монгол улсын арван буянт номын цагаан түүх нэрт судар оршивой”(XIII зуун) зохиолд:

Түүний хойно Жад⁶¹ Монголын газраа Тэмүжин суут Богд Чингис хаан төрж, замбуутив дэх гурван зуун жаран нэгэн хэлтэн, долоон зуун хорин нэгэн овогтон, арван зургаан их улсыг⁶² таван өнгө⁶³, дөрвөн харь болгон ертөнцийг тогтоосон нь их гайхамшигтын тул Мянган алтан хүрдэнг эргүүлэгч Хубилай Загравард (Чакраварди-хөр) Сэцэн хаан Алтан гэгээний ерөнхийн шүтээн найман цагаан гэр-ийг байгуулж, торгон их ёсыг тогтоосон нь....хэмээн Чингис хаан, Хубилай хааныг олон хэл, соёлтой улсыг эрхэндээ оруулж, эзэлсэн “Алтан хүрдэн эргүүлэгч хаан” гэж алдаршуулсан байна.

Саган Сэцэний Эрдэнийн товчид:

“Тэр мэт Самандабадра бурханы шашнаа дөрвөн тивд Алтан хүрдэн эргүүлэгч Чакраварди хаан хэмээн алдаршжээ....”

⁶¹ “Жад” гэдэг нь “харь” хэмээх утгатай.

⁶² Бурханы шашны домогт өгүүлснээр, Замбуутивд арван зургаан орон, мянган өчүүхэн орон, адил бус хүний зүйл гурван зуун жар, адил бус хэлний зүйл долоон зуун хорь ажээ.

⁶³ Таван өнгө улсад хөх Монгол, улаан Хятад, хар Төвөд, шар Сартуул, цагаан Солонгос эд бүгд болой.

Хубилай хааныг “арван буянт номын засгийг явуулж, дэлхийг төвшитгөөд, ахуй дэлхий дахиныг жаргуулснаар, тэр мэт мянган алтан хүрдийг эргүүлэгч Чакраварди сэцэн хаан хэмээн хотол зүгүүдэд алдаршин...”,

“Тэндээс Чакравардийн сэцэн хааны гоо Чамбуй хатнаас төрсөн Дорж, Мангала, Чингим, Номхон дөрвөн хөвгүүн, Сэцэг хэмээх ганц авхай буй” (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 94) хэмээн Хубилай хааны “Хүрдэн эргүүлэгч хаан”шиг төрийг удирдах мэргэн ухаан, мэдлэг чадвар, эрх мэдэл, алдар гавъяаг магтаад зогсохгүй түүний хатан болон хан хөвгүүд, гүнжийг нэрлэн дурджээ.

Шар туужид хүрдэн эргүүлэгч хааны тухайд:

“Олноо өргөгдсөн хаанаас янагш Намайг хөх хэмээх хаан хүртэл Хүрдэн орчуулагч зургаан Чакраварти хаан хэмээн алдаршвай.

Эзэн зарлиг болруун: Тэнгэр хурмаст тэнгэр эцэг юүгээн зарлигаар дэлхий дахины арван хоёр их хааныг эрхэндээ оруулж, ер ихэнх үйлсээ төсгөби би. Эдүгээ амран суу...

Сэцэн хаан бээр арван буянт номын засгийг явуулж, дэлхий дэхинийг энхжүүлэн жаргуулж, мянган алтан хүрднийг эргүүлэгч Чакравардийн Сэцэн хаан хэмээн хотол зүгүүдэд алдаршин, гучин зургаан жил хан орон суугаад наян хоёр насандаа шороо бэчин жил нөгчвэй. (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 56) Тус түүхийн эх сурвалжид Энэтхэг, Төвөдийн түүхэнд тодорч гарсан Чакраварди хаадыг дурдаад дэлхийн арван улсын их хааныг эрхэндээ оруулсан Юань гүрний Хубилай Сэцэн хаан бээр арван буянт номын ёсоор төрийн хэргийг явуулж байсан талаар дурдаад хаан суусан хугацаа, таалал төгссөн жилийг⁶⁴ тодорхой бичжээ.

Тэгвэл Лувсанданзаны “”Алтан товч” эх сурвалжид Чакраварди хааны талаар “Тэр ноён бээр үнэн, худал хоёрыг ялгаж засагласнаар тэдгээр хамаг ард нь тэр ноёныг маш ихэд өргөн хүндэлснээр, Энэтхэгийн эн тэргүүн Маха Самади хаан хэмээн алдаршвай. Хаадын язгуур нь түүнээс болов” хэмээгээд тэр хааны үр сад нь...”Алтан хүрдэт, Мөнгөн хүрдэт, Зэс хүрдэт, Төмөр хүрдэт хаан буюу Чакравардийн таван хаан” (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 28) гэж алдаршсан тухай дурджээ.

Хаадын үндсэн хураангуй алтан товчид Чакраварди хааны тухай

“Тэнгэрээс заяагаар төрсөн Тэмүжин Чингис хаан буюу...Таван өнгө, дөрвөн харь улсыг эхлэн, Замбутивын гурван зуун жаран нэгэн омогтон, долоон зуун хорин хэлтэн улсын алба гувчуурыг авч,

Гар газраа

Хөл хөсрөө

Амарлиулж, Чакраварди хаан мэт алдаршвай. Суут Чингис хаан хар могой жилт буюу. Дөчин таван насандаа бин барс жилд Онон мөрний тэргүүнээс эсөн хөлт цагаан тугаа байгуулж, хаан их ор суувай. (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 46-47) Үүнээс үзвэл Чингис хаанд Чакраварди хааны улс орныг эрхшээлдээ оруулж захирахаас гадна төрийг төвшитгөн, түмэн олныг амарлиулах эрдэм чадал төгс бүрдсэнийг илтгэнэ.

Ишбалданы (1835) Эрдэнийн эрихэд Чакраварди хааны тухай:

“Чингис хаан тэр ямагт Хятад, Төвд, Монгол гурав, Хачи, Хотон тэргүүтэн Замбутивийн хагас илүү төдийг эрхэндээ оруулсан энэ адил нь урьд Хятад, Төвд, Монгол гурвын хаан бусад хэн ч эс гарсан тул энэ нь орон аймаг зарим нэгэнд албат иргэн үгээгүү ядуу тав зургаан мянга тэргүүтнийг захирсан ноён өчүүхэн нэгнийг хүчний хүрд орчуулагч хаан хэмээн гүтгүүлсэн мэт

⁶⁴ Ц.Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгтэд Хубилай хааныг 1215-1294 он хүртэл 79 насласан гэжээ. Хубилай хаан 1294 онд, тавдугаар жарны хөх морин жилд таалал төгссөн хэмээсэн бол Шар туужид 82 насандаа шороон бичин нас нөгцөв гэжээ.

бус-д утга төгссөн дэлхийн эзэн хүчний хүрд орчуулагч тэнгэрийн бошогт их хаан магад мөн болой”. (МУИС, Монгол судлалын төв, 2006, хууд. 16-17) Тус түүхийн эх сурвалжид Чингис хааны эзэлсэн улсын дотор Хачи буюу исламын шашинтай улс орнуудыг дурджээ. Үүнээс үзвэл Чингис хаан өөр шашин шүтлэгтэй улс орнуудыг эрхэндээ оруулан мэргэн ухаанаар удирдсан Чакраварди хааны эрдэм чадлыг эзэмшсэн хаан байсныг илэрхийлнэ.

Галданы Эрдэнийн эрихэд хүрдэн эргүүлэгч хааны тухай

“Алт, мөнгө, зэс, төмөр хүрдэт таван Чакравардийн хаанууд нь амьтны цаглашгүй наснаас найман түмэн насны хэмжээ хүртэл гарав (МУИС, Монгол судлалын төв, МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим, 2006, хууд. 36) гэж хүрдэн эргүүлэгч хаан орчлонд залрах шалтгаан, хугацааг дурдсан байна.

Чингис хаан ийн зарлиг болруун: “Дээр хаан хурмаст эцэг юүгээ зарлигаар, дэлхий дэх эрсийн арван хоёр их хаануудыг эрхдээ оруулж, дэлэм буруу явдалтан өчүүхэн хаадыг дураараа болгоод, түгээмэл нармай улсаа зовон зөөж, зонхилон хурааж төгсгөн, ерд ихэнх хамаг үйлсээ бүтээж төгсгөв. Эдүгээ би сэтгэлээ амран суусугай” хэмээн зарлиг болоод (МУИС, Монгол судлалын төв, МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим, 2006, хууд. 107)

Чингис хаан Монгол, Тангуд, Хятад, Орос, Хотон тэргүүтэн замбутивийн хагаст буй таван өнгө, дөрвөн харийг эзэлснээс таван өнгө нь хөх Монгол, улаан Хятад, хар Төвд, шар Сартуул, цагаан Солонгос тав болой. Дөрвөн харь нь: Усан эрт охин, Зүүн муж, Өвчүүндээ нүдтэй, Нохой толгойт дөрөв болой. (МУИС, Монгол судлалын төв, МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим, 2006, хууд. 111) Энд бусад эх сурвалжийг бодвол Чингис хааны төрийг удирдах ёс зарчим болон эрхэндээ оруулсан улс орон, угсаатныг тодорхой дурдаж өгчээ.

Дармадалайн “Их Монголын оронд дээдийн ном хэрхэн дэлгэрсэн түүх” эх сурвалжид Чингис хааныг (Дармадалай, 2016) “Очирвааний хувилгаан, хүчний хүрдийг эргүүлэгч, их хаан, Эзэн Чингис гэж алдаршсан болой” (Дармадала, 2016, хууд. 58-59) хэмээн өргөмжлөн бичжээ. Уг эх сурвалжид Чингис хааныг “хүчний хүрдийг эргүүлэгч их хаан” гэж алдаршуулснаас гадна Буддын шашны их хөлгөний номын сахиус арван хангалын нэг, Монгол орныг хамгаалан сахигч, шимнусын омгийг дарагч, эр зориг, шударга ёс, тэсвэр хатуужил, тууштай байдлын бэлгэдэл догшин дүрт Очирваан бурханы хувилгаан хэмээн тодотгожээ.

Зава лам Лувсандаян мөн “Богд Эзэн хаан энэ нь хэдхэн зуун өрх айлыг эзэгнэсэн зарим ноёныг хүчний хүрдээр урвуулагч хэмээн зусардан магтаж үйлдсэн мэт бус жинхэнэ утга төгөлдөр, тэнгэр заяат, газрын Эсүрэн, хүчний хүрдээр урвуулагч, хувилсан номын их хаан мөн гэдэг нь магадтай юм” (Зава Дамдин, 2018, хууд. 72) хэмээн Чакраварди хэмээн алдаршсан их хааны суу алдар, эрдэм чадлыг магтжээ. Тус бүтээлд Чингис хааныг “хүчний хүрдээр урвуулагч” гэх цолоор алдаршуулсны зэрэгцээ газар дэлхийг бүтээгч, бурхан багшид номыг хүрд айлтгахыг дурдан мянган хигээст алтан хүрд өргөн барьсан Эсрүн тэнгэрийн хувилгаан дүр гэж өргөмжилсөн байна.

Буддын шашинд Бурхан багш болон Хүрдэн эргүүлэгч хааныг ард олны ашиг тус, амгалан жаргаланг бүтээхэд хязгааргүй их гавъяа байгуулдаг тул тэр хоёрын төрөх, их үйл хэрэг, зохиол бүтээл, нирваан дүр үзүүлэх, чандарлах үйлийг адил үйлдэж дурсан санадаг байна. Хүрдэн эргүүлэгч хааны эрх мэдэл, хүчний хүрд нь Бурхан багшийн номлосон хутагтын дөрвөн үнэн, шударга ёс, номын хүрднээс хамааралтай эргэдэг (Trevor Ling, 1973, p. 171) гэж тайлбарлажээ.

Монголд буддын шашин дэлгэрсэн үеэс монгол хаад буддын хувраг болон энгийн ард иргэдийг харилцааг номын ёсоор удирдан зохицуулах хүрдэн эргүүлэгч хааны үүрэг хүлээх болсноор чакраварди хаан хэмээх алдар цолыг хүртэн монголын түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэх болжээ.

Дүгнэлт

Монголын бурханы шашны түүх бичлэгт Абхидхармакоша шастирын ертөнцийн үүсэл, зүй тогтол, хэмжээс, тивүүдийн байрлал, хэлбэр дүрс, түүн дээр орших амьдрал, хаант төрийн үүсэл гарлын тухай, хааны хүний эрдэм чадал, эрх мэдэл, эд баялаг, эрдэнэсийн сангийн тухай ойлголтууд нөлөөлжээ.

Абхидхармакошакарика зохиолын Сүмбэр уул төвтэй сав ертөнцийн зүй тогтол, байгуулал нь босоо тэнхлэгт хүслийн, дүрст, дүрсгүй гэсэн гурван ертөнцийг дүрсэлдэг бол хэвтээ тэнхлэгт уул нурууд, гол мөрөн, нуур, далай, гол дөрвөн тив, түүнийг дагалдах найман жижиг тивүүдийн байрлалыг тодруулан харуулдаг. Тус шастир нь Энэтхэгийн соёлын нөлөөтэй космологи үзлээс гадна газар дэлхий, тэнгэрийн ертөнц, тэдгээрт оршин буй там, бирд, адгуус, хүн, асура, тэнгэр төрөлхтөн гэсэн олон төрөл зүйлийн амьдралын хэв маягийг дүрсэлсэн буддын шашны уламжлалт газарзүйн мэдлэгийг Монголчуудад таниулж өгснийг Монголын буддын шашны түүхийн эх сурвалжуудаас харж болно.

Монголын буддын шашны гурав дахь дэлгэрэлтийн үеэс Абхидхармакоша шастирт дурдсан “чакраварди хаан” хэмээх өргөмжлөл цол нь хаант төрийн үүсэл гарал, Монгол хаадын эрдэм чадал, эрх мэдэл, эд баялаг, шударга ёсыг тодотгон Монголын буддын шашны түүхийн эх сурвалжуудад бичигдэх болжээ. Монгол хаадыг чакраварди буюу хүрдэн эргүүлэгч хаан хэмээн түүхэн эх сурвалжуудад дурдахдаа олон хэл соёлтой, харь улсыг эрхэндээ хурааж арван буянт номын ёсоор төрийг удирдан, дэлхий дахиныг жаргуулсан их хаан гэж алдаршуулсан байна.

Монголд буддын шашин хүчтэй дэлгэрсэн XVI зуунаас төрийн ёс, номын ёсыг хослон барих үзэл санаа нэвтэрч, монголын түүх бичлэгт Монголын их хаадыг Чакраварди буюу хүрдэн эргүүлэгч хаан хэмээн бичих болжээ.

Ном зүй

1. Ариунаа, Э. (Хян.). (2015). *Буддын онолын шастарууд*. Улаанбаатар: Монголын Буддын судлалын хүрээлэн.
2. Банзаров, Д. (1891). *Черная Вьра или Шаманство у Монголов и другая статьи*. Санктпетербург: Место.
3. Банзаров, Д. (2007). *Бөө судлал буюу Монголын харын бөө*. (Д. Бадарч, Орч.) Улаанбаатар: Мөнхийн үсэг.
4. Бира, Ш. (2001). *Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа*. Улаанбаатар: Интерпресс.
5. Дамдинсүрэн, Ц. (2017). *Монголын уран зохиолын дээж зуун билэг оршвой*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
6. Дармадала. (2016). *Монгол орноо бурханы шашин дэлгэрсэн түүх*. (С. Гомбожав, Орч.) Улаанбаатар: Адмон принтинг.
7. Дулам, С. (2009). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Бит Пресс.
8. Зава Дамдин. (2018). *Алтан дэвтэр*. (С. Гантөмөр, Орч.) Улаанбаатар: Адмон принт.
9. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Галдан туслагч. Эрдэнийн эрх хэмээх түүх болой* (Боть. XX). Улаанбаатар: Соёмбо принтинг.
10. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Гүүш Лувсанданзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч* (Боть. V). Улаанбаатар: Соёмбо принтинг.
11. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Ишбалдан. Эрдэнийн эрх* (Боть. XIX). Улаанбаатар: Соёмбо принтинг.
12. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан. Алтан товч* (Боть. XII). Улаанбаатар: Соёмбо принтинг.

13. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Саган Сэцэн. Эрдэнийн товч* (Боть. VIII). Улаанбаатар: Соёмбо принтинг.
14. МУИС, Монгол судлалын төв. (2006). *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал: Шамбадар Цогт ахай. Эртний Монгол хаадын үндэсний их шар тууж оршиг* (Боть. VII). Улаанбаатар: Соёмбо принтинг.
15. Сүмбэ хамба Ишбалжир. (2017). *Галбарвас мод хэмээх шашины түүх*. (П. Ням-Очир, Орч.) Улаанбаатар: Амжилтын гарц.
16. Ganden Phodrang (Ed.). (2017). A Catalog of the works of the Seventeen Nalanda Masters. Tegchen Chosgling, Daramsala, HP, INDIA
17. Kyoung-joon Park. (2002). On the Problem of the Origin of Cakravartin. *International Journal of Buddhist thought and Culture*, I, 127-136.
18. Mi pham rnam rgyal rgya mtsho. (1998). *Dam pa'i chos mngon pa mdzod kyi mchan 'agrel rin po che'i do shal blo gsal dgyes pa'i mgul rgyan zhes bya ba bzhugs so, mtho slob snga a'gyur rnying ma pa'i bde don lhan khang*. Varanasi: CIHTS.
19. Potter, K. H. (Ed.). (1999). *Encyclopedia of Indian Philosophies* (Volume. III). Delhi: Motilal Banarsidass Publishers.
20. Rgyal ba dge 'adun 'agrub. (2000). *Dam pa'i chos mngon pa'i mdzod kyi rnam par bshad pa thar lam gsal byed, wa'na mto slob dge ldan spyi las khang*. Varanasi: CIHTS.
21. Rgyal ba dge 'adun 'agrub. (2000). *Dam pa'i chos mngon pa'i mdzod kyi rnam par bshad pa thar lam gsal byed, wa'na mto slob dge ldan spyi las khang*. Varanasi: CIHTS.
22. Slo dpon dbyig gnyin. (1998). *Chos mngon pa mdzod kyi rang 'grel, wa'na mto slob dge ldan spyi las khang*. Varanasi: CIHTS.
23. Sunait Chutintarnond. (1988). Cakravartin: Ideology, reason and manifestation of Siamese and Burmese kings in Traditional Warfare (1538-1854). *Crossroads: An Interdisciplinary Journal of Southeast Asian Studies*, IV(1), 46-56.
24. Trevor Ling. (1973). *The Buddha, The Social-Revolutionary Potential of Buddhism*. Onalaska, WA, USA: Pariyatti Press.

Analysis of some concepts of Abhidharmakosha in the historical source texts of Mongolian Buddhism

Historical sources of the spread of Buddhism in Mongolia often refer to the Abhidharmakosha, which was composed by the Indian philosopher Vasubandhu. For example, historical sources including "White History", Sumbe Khanbo Ishbaljir's (1704-1788) "History of rise, progress. and downfall of Buddhism in India, Tibet, China and Mongolia, a wish-fulfilling Kalpavriksha tree", Dharmadala's "The clear narrator of white lotus rosary, how to spread the Supreme Dharma in the land of Great Mongolia", Zava Damdin's (1867-1937) "The Golden book of the spread of Buddhism in Great Mongolia" cited from some concepts of Abhidharmakosa.

The cosmological ideas in Abhidharmakosha, the position, directions, and shapes of the continents, the unique characteristics of the body and the age of the living beings in there, the ideology and content of the Buddhist teachings, the translation process and date of Abhidharmakosha into Mongolian language, honoring Mongolian kings as Chakravartin king" is quoted in the sources mentioned above.

The presentation aims to analyze the above concepts and discover how Abhidharmakosha's influence affected Mongolian Buddhist historiography